



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/20/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Тусгай чиг үүргийн аудитын газрын
захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан
Утас: 261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Бат-Эрдэнэ
Утас: 261729 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Аудитор: Б.Батхишиг
Утас: 261729 Цахим хаяг: batkhishigb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал	11
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.1 Харьяа байгууллагууд	23
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч	23
5.3 Түүвэрт хамрагдсан байгууллагад илэрсэн санхүүгийн зөрчил	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУДШ	Монгол Улсын Дээд Шүүх
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт Бичиг
НТШ	Нээлттэй сонгон шалгаруулалт
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д.ГАНЗОРИГ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026. 04. 27 № 1145
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын шүүхийн тогтолцооны шинэчлэлд хувь нэмэр оруулах зорилгоор Европын холбооны 1.5 сая еврогийн санхүүжилттэй “Твиннинг төсөл”-ийг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн байна. Тус төслийг Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны хэмжээнд 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хэрэгжүүлэхээр байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүх хуралдааныг шууд дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Шүүх хуралдааны шууд дамжуулалтын

суваг"-ын үйл ажиллагаанд зориулж 1,430.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн байна.

Хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацааг бууруулах зорилтын хүрээнд Монгол Улсын дээд шүүхийн үйл ажиллагаанд хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх суурь судалгааг 2025-2027 он хүртэл үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс тайлант онд судалгааны ажлыг эхлүүлж 239.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 онд хэрэгжүүлэх "Хяналтын дээд шатны шүүн таслах ажиллагаа" хөтөлбөрийн хүрээнд хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн хэргийн эзлэх хувийг 94.0 хувьд хүргэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 94.1 хувьтай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,587,163.8	1,024,818.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,099,819.7	255,915.3
33	АВЛАГА	188.8	112,337.4
34	УРЬДЧИЛГАА	2,057,174.1	57,238.6
35	БАРАА МАТЕРИАЛ	489,385.5	599,326.9
36	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	7,940,595.7	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,155,985.2	33,824,171.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,155,985.2	33,824,171.0
39200	Биет хөрөнгө	19,413,704.6	32,623,871.0
39300	Биет бус хөрөнгө	742,280.6	1,200,300.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	38,743,149.0	34,848,989.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,025,396.5	1,175,143.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,025,396.5	1,175,143.0
41300	Өглөг	8,025,396.5	1,175,143.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	30,717,752.5	33,673,846.2
51	Засгийн газрын хувь оролцоо	30,717,752.5	33,673,846.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,428,220.1	1,428,220.1
51200	Хуримтлагдсан үр дүн	27,731,688.0	31,234,682.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,557,844.3	1,010,943.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	38,743,149.0	34,848,989.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	41,461,283.6	28,294,648.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,219,585.3	28,294,648.7
122	Тусламжийн орлого	227,040.0	26,491,070.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,241,698.4	0.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	17,635,888.6	23,756,083.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,635,888.6	23,756,083.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,060,428.1	22,876,274.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,775,715.7	14,769,008.6

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,348,934.7	1,836,011.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	264,950.7	538,349.1
2104	Хангамж, бараа материалын зардал	709,798.5	777,732.1
2105	Норматив зардал	10,580.0	1,490.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210,073.2	309,654.6
2107	Томилолт, зочны зардал	492,841.8	427,722.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	265,577.7	311,810.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,981,955.8	3,904,496.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,575,460.6	879,808.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	23,825,395.0	4,538,565.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	32,790.8	1,582,514.4
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(32,790.8)	(1,582,514.4)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	23,792,604.2	2,956,050.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,904,848.3	6,904,848.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	114,283.8	114,283.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,019,132.1	7,019,132.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(93,983.8)	(93,983.8)
5	Тайлант үеийн үр дүн	23,792,604.2	23,792,604.2
6	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,717,752.5	30,717,752.5
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	546,943.5	546,943.5
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	31,264,696.0	31,264,696.0
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(546,900.6)	(546,900.6)
11	Тайлант үеийн үр дүн	2,956,050.7	2,956,050.7
12	<u>2025 оны 12-р сарын 31 -нээрх үлдэгдэл</u>	<u>33,673,846.2</u>	<u>33,673,846.2</u>

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	36,268,351.8	26,530,899.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,026,653.5	26,530,899.5
120	Нийтлэг татварын бус орлого	8,026,653.5	39,828.8
13	Тусламжийн орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,241,698.4	26,491,070.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,614,059.3	21,550,692.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,614,059.3	21,550,692.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,038,598.8	20,560,570.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,775,034.9	14,728,336.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,348,934.7	1,836,035.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	299,513.4	505,106.4
2104	Хангамж, бараа материалын зардал	507,929.9	828,734.4
2105	Норматив зардал	10,580.0	1,490.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	233,595.3	188,333.2
2107	Томилолт, зочны зардал	527,899.6	399,657.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	328,847.4	276,982.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,006,263.6	1,795,895.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,575,460.6	990,122.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	19,654,292.5	4,980,207.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	11,674,592.8	12,824,111.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,674,592.8	12,824,111.6
2200	Дотоод эх үүсвэрээр	11,674,592.8	12,824,111.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(11,674,592.8)	(12,824,111.5)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	7,979,699.7	(7,843,904.4)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	120,120.0	8,099,819.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,099,819.7	255,915.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	29,808,657,200.00	26,435,456,859.20	3,373,200,340.80	88.7
12	Татварын бус орлого	29,808,657,200.00	26,435,456,859.20	3,373,200,340.80	88.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,808,657,200.00	26,351,866,859.20	3,456,790,340.80	88.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,718,957,200.00	22,377,924,967.60	3,341,032,232.40	87.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,549,677,200.00	21,560,552,405.60	2,989,124,794.40	87.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,387,976,600.00	14,728,336,278.87	659,640,321.13	95.7
210101	Үндсэн цалин	8,265,936,500.00	8,856,783,793.97	(590,847,293.97)	107.1
210102	Нэмэгдэл	3,588,616,100.00	2,978,140,231.54	610,475,868.46	83.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,047,026,400.00	1,545,938,439.86	501,087,960.14	75.5
210104	Урамшуулал	1,486,397,600.00	1,347,473,813.50	138,923,786.50	90.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,928,745,400.00	1,836,035,211.69	92,710,188.31	95.2
210201	Тэтгэврийн даатгал	1,314,569,500.00	1,250,231,814.29	64,337,685.71	95.1
210202	Тэтгэмжийн даатгал	151,746,100.00	146,867,407.96	4,878,692.04	96.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	77,309,000.00	73,165,348.60	4,143,651.40	94.6
210204	Ажилгүйдлийн даатгал	75,856,500.00	72,816,764.30	3,039,735.70	96.0
210205	Эрүүл мэндийн даатгал	309,264,300.00	292,953,876.54	16,310,423.46	94.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	669,433,000.00	487,228,712.94	182,204,287.06	72.8
210301	Гэрэл, цахилгаан	273,187,300.00	196,895,855.64	76,291,444.36	72.1
210302	Түлш, халаалт	142,067,600.00	91,606,657.01	50,460,942.99	64.5
210303	Цэвэр, бохир ус	53,562,700.00	21,218,439.00	32,344,261.00	39.6
210304	Байрны түрээс	200,615,400.00	177,507,761.29	23,107,638.71	88.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,072,731,100.00	832,274,109.88	240,456,990.12	77.6
210401	Бичиг хэрэг	223,978,400.00	129,853,250.35	94,125,149.65	58.0
210402	Тээвэр, шатахуун	91,060,600.00	66,318,500.00	24,742,100.00	72.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	124,505,700.00	96,338,635.23	28,167,064.77	77.4
210404	Ном, хэвлэл	136,077,000.00	77,780,369.30	58,296,630.70	57.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,921,800.00	7,441,400.00	26,480,400.00	21.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	463,187,600.00	454,541,955.00	8,645,645.00	98.1
2105	Норматив зардал	17,585,800.00	1,490,000.00	16,095,800.00	8.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,585,800.00	1,490,000.00	16,095,800.00	8.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,315,064,500.00	1,123,782,376.00	1,191,282,124.00	48.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,034,634,900.00	431,074,828.80	603,560,071.20	41.7
210602	Тавилга	666,588,400.00	162,301,100.00	504,287,300.00	24.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	19,707,100.00	5,829,500.00	13,877,600.00	29.6
210604	Урсгал засвар	594,134,100.00	524,576,947.20	69,557,152.80	88.3
2107	Томилолт, зочны зардал	469,635,500.00	399,657,012.70	69,978,487.30	85.1
210701	Гадаад албан томилолт	358,702,100.00	362,323,012.70	(3,620,912.70)	101.0
210702	Дотоод албан томилолт	85,593,600.00	17,388,000.00	68,205,600.00	20.3
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	25,339,800.00	19,946,000.00	5,393,800.00	78.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	558,848,600.00	355,858,969.67	202,989,630.33	63.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	205,002,000.00	84,290,807.02	120,711,192.98	41.1

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	70,493,900.00	64,344,069.00	6,149,831.00	91.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	11,882,800.00	9,007,744.00	2,875,056.00	75.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	244,729,100.00	189,822,202.65	54,906,897.35	77.6
210807	Газрын төлбөр	26,740,800.00	8,394,147.00	18,346,653.00	31.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,129,656,700.00	1,795,889,733.85	333,766,966.15	84.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,681,000.00	4,680,739.03	26,000,260.97	15.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,098,975,700.00	1,791,208,994.82	307,766,705.18	85.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,169,280,000.00	817,372,562.00	351,907,438.00	69.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,169,280,000.00	817,372,562.00	351,907,438.00	69.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	845,280,000.00	769,872,562.00	75,407,438.00	91.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	324,000,000.00	47,500,000.00	276,500,000.00	14.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,089,700,000.00	3,973,941,891.60	115,758,108.40	97.2
220001	Барилга байгууламж	561,800,000.00	549,710,000.00	12,090,000.00	97.8
222001	Тоног төхөөрөмж	3,527,900,000.00	3,424,231,891.60	103,668,108.40	97.1
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	83,590,000.00	(83,590,000.00)	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(83,590,000.00)	83,590,000.00	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(83,590,000.00)	83,590,000.00	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	100.0
610001	Төсвийн байгууллага	2	2	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	240	196	44.00	81.7
620001	Удирдах ажилтан	11	11	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	189	143	46.00	75.7
620003	Үйлчлэх ажилтан	40	42	(2.00)	105.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	55,513,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	55,513,300.00
122	Тусламжийн орлого	-	55,513,300.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	55,513,300.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	55,513,300.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	55,513,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	17,877,678.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	17,877,678.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	17,877,678.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	17,877,678.40
210302	Түлш, халаалт	-	4,605,278.40
210304	Байрны түрээс	-	13,272,400.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	37,635,621.60
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(37,635,621.60)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(37,635,621.60)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Монгол Улсын дээд шүүхийн эрхэм зорилгыг “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллагыг бататган бэхжүүлж, хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хууль дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах” гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын дээд шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааг Шүүхийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.6 “Улсын дээд шүүхийн Тамгын газрын бүтэц, орон тоо, албан тушаалын цалингийн хэмжээг ажлын ачаалал, онцлогийг харгалзан тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн батална. Улсын дээд шүүхийн Тамгын газар нь энэ хуулийн 25.8.8-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий нэгжтэй байна”, 24 дүгээр зүйлийн 24.3 “Шүүхийн академийн бүтэц, орон тоо, ажиллах журам, шүүгчийн сургалтын хөтөлбөрийг Улсын дээд шүүхийн танхимын саналыг харгалзан Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч батална” гэж заасан байна.

Тус төсвийн ерөнхийлөн захирагчид Монгол Улсын дээд шүүхийн тамгын газар болон Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн академийн төсвийн шууд захирагчид хамаарч байна.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль-нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хөрөнгө оруулалтын тухай хууль - өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хууль - нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн албаны тухай хууль- нэмэлт оруулах тухай;
- Захиргааны ерөнхий хууль-нэмэлт оруулах тухай;
- Зөрчлийн тухай хууль;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;
- Засгийн газрын 2025 оны “Томилолтын зардлыг шинэчлэн тогтоох тухай” 133 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэмд заасан чиг үүрэг, Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 95 дугаар захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу харьяа байгууллагуудын тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийсэн бөгөөд дотоод аудитаар хийсэн ажлын тайлан, илрүүлэлт болон дүгнэлт, зөвлөмжөөс харахад дотоод хяналтыг үр дүнтэй болсон гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2017 оны 35 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу шинэчлэн боловсруулж, Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 87 дугаар захирамжаар батлан санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Шинэчлэн батлагдсан бодлогын баримт бичиг нь холбогдох хууль, журам, стандартын шаардлагад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,894.1 сая төгрөгөөр буюу 10.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,099.8	255.9	(7,843.9)
Авлага	0.1	112.3	112.2
Урьдчилгаа	2,057.2	57.2	(2,000.0)
Бараа материал	489.4	599.3	109.9
Бусад эргэлтийн хөрөнгө	7,940.6		(7,940.6)
Үндсэн хөрөнгө	20,156.0	33,824.2	13,668.2
Нийт хөрөнгө	38,743.1	34,849.0	(3,894.1)
Богино хугацаат өр төлбөр	8,025.4	1,175.1	(6,850.3)
Засгийн газрын оруулсан капитал	1,428.2	1,428.2	0.0
Хуримтлагдсан үр дүн	27,731.7	31,234.7	3,503.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,557.8	1,010.9	(546.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	38,743.1	34,849.0	(3,894.1)

Эх сурвалж: Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүн зэрэг дансдууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 255.9 сая төгрөг болж, өмнөх оноос 7,843.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	8,099.8	255.9	(7,843.9)
Дүн	8,099.8	255.9	(7,843.9)

Эх сурвалж: Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны 8,099.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлд Хангарди ордны их засварын ажлын барьцааны төлбөр 5,759.1 сая төгрөг, бусад ажлын барьцааны төлбөр 138.4 сая төгрөг, тавилгын гэрээний үлдэгдэл төлбөр 2,127.9 сая төгрөг, ахмадын сангийн үлдэгдэл 74.4 сая төгрөг тус тус бүртгэгдсэн байна.

Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 7,843.9 сая төгрөгөөр буурсан нь Хангарди ордны барилгын их засварын ажлын төлбөрийг төлснөөс голлон шалтгаалсан байна.

Тайлант оны эцэст мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 255.9 сая төгрөг байгаагаас барьцаа хөрөнгийн дансанд байршиж буй чанарын баталгаат хугацааны төлбөр 250.1 сая төгрөг, техник хяналтын дансны үлдэгдэл 5.8 сая төгрөгөөс тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний барьцаа 83.6 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүйгээс жилийн эцсээр төрийн санд буцаан төвлөрүүлсэн, урсгал зардлын санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний барьцаа 21.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүйгээс тайлант оны үйл ажиллагаанд зарцуулсан байна.
- Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар нь тайлант онд 6 гэрээг үнийн дүнгүйгээр байгуулж, гүйцэтгэгчийн ирүүлсэн нэхэмжлэлийн дагуу нийт 35.8 сая төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн байна.

3.4.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 112.3 сая төгрөг болж, өмнөх оноос 112.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлага дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	0.1	0	(0.1)
Татаас, санхүүжилтийн авлага	-	112.3	112.3
Дүн	0.1	112.3	112.2

Эх сурвалж: Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл 112.2 сая төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтын данснаас барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн чанарын баталгааны барьцааны төлбөр 83.6 сая төгрөг, ахмадын сангийн дансны үлдэгдэл болох 28.7 сая төгрөгийг тус тус татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэнтэй холбоотойгоор голлон нэмэгдсэн байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 57.2 сая төгрөг болж, өмнөх оноос 2,000.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	2,057.2	57.2	(2,000.0)
Дүн	2,057.2	57.2	(2,000.0)

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 2,000.0 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд олгосон улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн урьдчилгааг тайлант онд хянан баталгаажуулж, үндсэн хөрөнгөнд бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант оны эцэст урьдчилгаа дансны үлдэгдэл 57.2 сая төгрөгийн үлдэгдэлд шүүгчдийн амь нас, эрүүл мэндийн даатгалын төлбөр 55.1 сая төгрөг буюу 96.3 хувийг, автомашины зогсоолын түрээсийн төлбөр 2.1 сая төгрөг буюу 3.7 хувийг тус тус эзэлж байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 599.3 сая төгрөг болж, өмнөх оноос 109.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материал дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Хангамжийн материал	489.4	599.3	109.9
Бичиг хэргийн материал	114.6	86.5	(28.1)
Аж ахуйн материал	202.6	358.7	156.1
Түлш, шатах тослох материал	8.6	13.3	4.7
Бусад хангамжийн материал	163.6	140.9	(22.7)
Дүн	489.4	599.3	109.9

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд бараа материал дансны үлдэгдэл 109.9 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 156.1 сая төгрөгөөр, түлш шатах тослох материал 4.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна. Харин бичиг хэргийн материал 28.1 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 22.7 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Тайлант онд 1,103.1 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч орлогоор бүртгэн, 993.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 599.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт бараа материалын 93.2 хувь нь Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын, 6.8 хувь нь Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн академийн санхүүгийн тайланд тусгагдсан байна.

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 7,940.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	7,940.6	-	(7,940.6)
Дүн	7,940.6	-	(7,940.6)

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эхний үлдэгдлийн 7,940.6 сая төгрөг нь хөрөнгө оруулалттай холбоотой Гранд Август ХХК-д 5,812.7 сая төгрөгийн, Пи Пи Пи Эм Жи Эл ХХК-д 2,127.9 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

Тайлант хугацаанд бусад эргэлтийн хөрөнгийн данс 7,940.6 сая төгрөгөөр буурсан нь эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилгын их засварын төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусан улсын комисс хүлээн авч, байгууллагын барилгын өртөгт капиталжуулсантай холбоотой байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл цэвэр дүнгээр 33,824.2 сая төгрөг болж, өмнөх оноос 13,668.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Биет хөрөнгө	19,413.7	32,623.9	13,210.2
Барилга, байгууламж, орон сууц	16,224.2	23,753.8	7,529.6
Авто-тээврийн хэрэгсэл	331.6	1,898.6	1,567.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,272.9	4,183.9	1,911.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	581.9	2,605.1	2,023.2
Бусад үндсэн хөрөнгө	3.1	182.5	179.4
Биет бус хөрөнгө	742.3	1,200.3	458.0
Программ хангамж	82.9	570.1	487.2
Бусад биет бус хөрөнгө	659.4	630.2	(29.2)
Дүн	20,156.0	33,824.2	13,668.2

Эх сурвалж: Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 13,668.2 сая төгрөгөөр өссөн нь бүртгэлийн ангиллын өөрчлөлт, хөрөнгийн капиталжуулалт, шинээр бэлтгэж ашиглалтад хүлээн авсан болон балансаас балансад шилжүүлэн авсан хөрөнгийн өөрчлөлтөөс голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй барилгын их засварын 7,940.5 сая төгрөгийн гүйцэтгэлийг барилгын өртөгт капиталжуулсан;
- Улсын төсвийн хөрөнгөөр 4,057.5 сая төгрөгийн, урсгал зардлын эх үүсвэрээр 1,614.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэн хүлээн авсан;
- Өмнөх оны урьдчилж төлсөн зардлын дансанд бүртгэлтэй 2,127.9 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн;
- Үнэ шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор 1,307.4 сая төгрөгөөр тоног төхөөрөмжийн үнэлгээг нэмэгдүүлсэн;
- Балансаас балансад 334.8 сая төгрөгийн барилгын их засварын зураг төсвийг шилжүүлж хүлээн авсан;
- Хандив, тусламжаар 56.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шинээр бүртгэсэн;

Мөн тайлант хугацаанд 2,049.7 сая төгрөгийн элэгдлийн зардлыг тооцож, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 410, 697 дугаар тогтоолоор 283.1 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 2,173.1 сая төгрөгийн хөрөнгийг бусад шүүхийн байгууллагуудад балансаас балансад шилжүүлсэн байна.

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 1,175.1 сая төгрөг болж, өмнөх оноос 6,850.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөр дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Байгууллагад өгөх өглөг	8,025.4	1,122.4	(6,903.0)
Ажилчидтай холбогдсон өглөг	-	50.6	50.6
Хувь хүмүүст өгөх өглөг	-	2.0	2.0
Дүн	8,025.4	1,175.0	(6,850.4)

Эх сурвалж: Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эхний үлдэгдэлд хөрөнгө оруулалттай холбоотой Гранд Авгуш ХХК-д 5,812.7 сая төгрөгийн, Вертексмон ХХК-д 84.8 сая төгрөгийн, Пи Пи Пи Эм Жи Эл ХХК-д 2,127.9 сая төгрөгийн өглөг тус тус бүртгэгдсэн байна.

Тайлант хугацаанд өр төлбөр дансны үлдэгдэл буурахад өмнөх онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилгын их засварын санхүүжилтийн өглөгийг барагдуулсан нь голлон нөлөөлсөн байна. Мөн цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын өглөг 50.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь богино хугацаат өр төлбөрийн өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Тайлант хугацааны эцэс дэх өр төлбөр дансны үлдэгдэлд 354.9 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн өглөг, шинээр үүссэн гүйцэтгэгч байгууллагуудад төлөх 767.5 сая төгрөгийн өр төлбөр тус тус бүртгэгдсэн байна.

Нийт өр төлбөрийн 70.6 хувийг Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын өглөг, 29.4 хувийг Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн академийн өглөг тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар нь тайлант онд 26.4 сая төгрөгийн цалин, урамшууллын өглөг үүсгэсэн байна.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 33,673.8 сая төгрөг болж, өмнөх оноос 2,956.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	1,428.2	1,428.2	-
Хуримтлагдсан үр дүн	29,289.5	32,245.6	2,956.1
Өмнөх үеийн үр дүн	3,939.1	28,278.7	24,339.6
Тайлант үеийн үр дүн	23,792.6	2,956.1	(20,836.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,557.8	1,010.9	(546.9)
Дүн	30,717.7	33,673.8	2,956.1

Эх сурвалж: Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,956.1 сая төгрөгөөр өсөхөд тайлант хугацааны үр дүн нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэхээр заасан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр, тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хавсаргаж ирүүлсэн байна.

3.5.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төлөвлөлт

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны төсвийн төсөлд хөрөнгийн зардлыг 5,632.8 сая төгрөгөөр, урсгал зардлыг 35,244.2 сая төгрөгөөр нийт 40,877.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар хөрөнгийн зардлыг 5,600.0 сая төгрөгөөр, урсгал зардлыг 27,295.7 сая төгрөгөөр, нийт 32,895.7 сая төгрөгөөр баталсан бөгөөд өргөн барьсан төсвөөс 19.5 хувиар бууруулсан байна.

Монгол Улсын 2025 оны 07 дугаар сарын Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хөрөнгийн зардлыг 4,089.7 сая төгрөгөөр, урсгал зардлыг 25,718.9 сая төгрөгөөр, нийт 29,808.7 сая төгрөгөөр буюу өмнө батлагдсан төсвийн 9.4 хувиар хасаж тодотгосон байна.

Тайлант хугацаанд Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-д заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч зардлын эдийн засгийн зүйл, хөтөлбөр, арга хэмжээний ангилалд 6.0 сая төгрөгийн дүнтэй нэг удаагийн зохицуулалт хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлант хугацаанд улсын төсвөөс 26,435.6 сая төгрөгийн санхүүжилт авч 26,351.9 сая төгрөгийг зарцуулж, 83.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн татаас, санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 26,351.9 сая төгрөг буюу батлагдсан төсвийн 88.4 хувийг эзэлж байгаа нь санхүүжилтийн эрх бүрэн нээгдээгүйтэй холбоотойгоор 3,456.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсоноос шалтгаалсан байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	24,344.7	21,392.8	2,951.9	87.9
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	124.6	25.0	99.6	20.1
80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	61.7	52.6	9.1	85.3
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,169.3	817.4	351.9	69.9
82321	Шинжээч орчуулагч хэлмэрчийн зардал	18.8	6.6	12.2	35.2
80918	Хөрөнгийн зардал	4,089.7	4,057.5	32.2	99.2
70702	Хяналтын дээд шатны шүүн таслах үйл ажиллагааны зардал	29,808.7	26,351.9	3,456.8	88.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Судалгааны үр дүн

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Үүнд:

Монгол Улсын дээд Шүүхийн Ерөнхий шүүгчийн харьяа байгууллагуудын цалин хөлс, орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн судалгааны үр дүнгээс харахад тайлант онд батлагдсан төсөв, орон тоог бууруулан тодотгосон бөгөөд тайлант онд нийт 43 орон тоо дутуу ажилласнаас цалин хөлсний зардлаас нийт 659.6 сая төгрөг хэмнэгдсэн байна.

Хүснэгт 11. Цалингийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	<i>/сая төгрөгөөр</i>		
	Монгол Улсын дээд Шүүхийн Тамгын газар	Шүүхийн академи	Нийт дүн
Анх батлагдсан орон тоо	264	61	325
Тодотгосон орон тоо	202	56	258
Орон тооны гүйцэтгэл	170	45	215
Орон тооны зөрүү	(32)	(11)	(43)
Анх батлагдсан цалингийн төсөв	14,178.8	2,670.5	16,849.
Тодотгосон төсөв	12,926.0	2,462.0	15,388.0
Гүйцэтгэл	12,509.4	2,218.9	14,728.3
Хэтрэл/Хэмнэлт	(416.6)	(243.0)	(659.6)

Албан хаагчдын нийтийн тээврийн унаа, өдрийн хоолны зардлын хэмжээний тухайд Монгол Улсын дээд Шүүхийн Тамгын газрын даргын 2024 оны А/73 дугаар тушаалаар, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн захирлын 2024 оны А/38 дугаар тушаалаар ажлын нэг өдрийн хоолны нөхөх төлбөрийг 32.0 мянган төгрөгөөр, унааны нөхөх төлбөрийг 3.0 мянган төгрөгөөр тус тус тогтоосон бөгөөд тайлант онд шинэчлэн тогтоогоогүй байна.

Хүснэгт 12. Унаа хоолны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Байгууллагын нэр	<i>/сая төгрөгөөр/</i>		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/хэмнэлт
1	МУДШ-ийн Тамгын газар	1,626.0	1,248.0	(378.1)
2	Шүүхийн академи	421.0	123.0	(298.0)
Нийт дүн		2,047.0	1,371.0	(676.0)

Монгол Улсын Дээд Шүүхийн Тамгын газрын тухайд гадаад албан томилолттой холбоотой 29 арга хэмжээнд 342.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 33 арга хэмжээнд 322.9 сая төгрөгийг зарцуулсан бол Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи нь 5 арга хэмжээнд 45.9 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд аудитаар тушаал шийдвэргүй болон хууль тогтоомжид нийцээгүй зөрчил илрээгүй байна.

Монгол Улсын Дээд Шүүхийн Тамгын газар нь тайлант онд хэвлэл мэдээллийн 3 байгууллагатай 53.7 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулж ажилласан бол Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи нь 4 байгууллагатай 44.1 сая төгрөгийн гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн харьяа байгууллагуудын төсвөөс тайлант онд төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой зардал гараагүй байна.

3.5.4 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталж, нийт 42 төсөл арга хэмжээг 7,373.8 сая төгрөгийн төсөвтэйгээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 7,373.8 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар тусгаснаас 6,146.1 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг нээлттэй

тендер шалгаруулалтын аргаар, 1,126.0 сая төгрөгийг харьцуулалтын аргаар, 101.7 сая төгрөгийг шууд худалдан авалтын аргаар хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

Худалдан авах ажиллагааны тайланг 2026 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр эрх бүхий байгууллагад хүргүүлсэн бөгөөд гүйцэтгэлээр нийт 6,385.4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авснаас 5,774.5 сая төгрөгийн худалдан авалтад нээлттэй тендер шалгаруулалтын арга, 509.2 сая төгрөгийн худалдан авалтад харьцуулалтын арга, 101.7 сая төгрөгийн худалдан авалтад шууд худалдан авалтын аргыг тус тус ашиглаж, нийт гүйцэтгэл 86.5 хувьтай тайлагнагдсан байна. Мөн санхүүжилтийн эрх нээгдээгүй, санхүүжилт олгогдоогүйгээс 371.6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зарласан боловч хэрэгжээгүй байна.

Хүснэгт 11. Тухайн жилийн худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Нэр	Нийт дүн	Төлөвлөгөө			Нийт дүн	Гүйцэтгэл			Зөрүү	%
		Нээлттэй	Харьцуулалт	ШХА		Нээлттэй	Харьцуулалт	ШХА		
Улсын дээд шүүхийн Тамгын газар	6,417.2	5,287.5	1,028.0	101.7	5,800.4	5,287.5	411.2	101.7	616.8	90.3
Шүүхийн академи	956.6	858.6	98.0		585.0	487.0	98.0		371.6	61.2
Дүн	7,373.8	6,146.1	1,126.0	101.7	6,385.4	5,774.5	509.2	101.7	988.4	86.5

Аудитын илрүүлэлт: Монгол Улсын дээд Шүүхийн Тамгын газар нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог боловсруулаагүй, зарим гэрээний ажлын даалгавар, техникийн үзүүлэлтийг ерөнхий байдлаар тусгасан, мөн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдээгүй, худалдан авалтын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байна.

3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 онд хэрэгжүүлэх “Хяналтын дээд шатны шүүн таслах ажиллагаа” хөтөлбөр болон түүний хүрэх үр дүнг илэрхийлэх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтүүдийг баталсан байна. Тус хөтөлбөрийн хүрээнд шүүн таслах ажиллагааны чанар, тэгш хүртээмжийг сайжруулах, шударга шүүхээр шуурхай шүүлгэх иргэний эрхийг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацааг бууруулах зорилтыг тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Мөн хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн хэргийн эзлэх хувийг 94 хувьд хүргэхээр зорилт тавьсан бол тайлант оны гүйцэтгэлээр уг үзүүлэлт 94.1 хувьтай гарч, төлөвлөсөн түвшнийг давсан бөгөөд гүйцэтгэлийг 100 хувьтай биелсэн гэж тайлагнасан байна.

3.5.6 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг нийт 55.5 сая төгрөгөөр бүрдүүлж, үүнээс түлш, халаалтын зардалд 4.6 сая төгрөг, байрны түрээсийн төлбөрт 13.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан бөгөөд үлдэгдэл 37.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад тавих дотоод хяналт болон төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн уялдааг сайжруулах, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ, зах зээлийн үнийг холбогдох хууль, журам, стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэн тогтоох, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоох, ашиглалтгүй болон цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасах, хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилтийг хангах, зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн захирагчийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Батхишиг, ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 01/1159 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 17,668.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 176.6 сая төгрөгөөс тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлснээр бичгийн цаас, хэвлэгчийн хорны зардал зэргээс нийт 86.0 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна. Мөн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн сургалтууд, уулзалт, хөтөлбөрийн хорооны хуралдааныг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулснаар түрээс, шатахуун, албан томилолтын зардлаас нийт 319.1 сая төгрөгийн хэмнэлт бий болсон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Харьяа байгууллагуудад нийцлийн асуудлаар нийт 689.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 3 албан шаардлага хүргүүлсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Харьяа байгууллага

Аудитын илрүүлэлт:

Тайлант онд Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 110.7 сая төгрөгийн 13 удаагийн зарлагын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш гэрээний дүнтэй 549.9 сая төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэргийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Төсвийн ерөнхийлөн захирагч

Илрүүлэлт: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 689.0 сая төгрөгийн нийцлийн зөрчил илэрсэн нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн зөрчилтэй харьцуулахад нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.5 "өөрийн агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1 "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагуудад тавих дотоод хяналтыг сайжруулж, хууль тогтоомж, холбогдох журам зааврын хэрэгжилтийг хангаж ажиллах.

4.4.2.2 Түүвэрт хамрагдсан байгууллагад илэрсэн нийцлийн зөрчил

Илрүүлэлт: Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээтэй холбоотой дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Төсөв захирагч нь 19.6 сая төгрөгийн “Сургалтын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулсан боловч ажил, үйлчилгээг бүрэн гүйцэтгээгүй байхад төлбөрийг бүрэн шилжүүлсэн;
- Зарим ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт, гэрээ дүгнэсэн актыг үйлдээгүй байхад, нийт 8.8 сая төгрөгийн төлбөрийг гүйцэтгэгч байгууллагуудад бүрэн шилжүүлсэн;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн

5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа гэрээнд заасан ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад хугацаанаас өмнө гэрээг дүгнэж төлбөрийг бүрэн шилжүүлдэг, зарим бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 2 байгууллагын 26.5 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс, 1.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 16.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 8.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж хүргүүлснийг 91.6 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	2	1.9	2	1.9	100
2	Албан шаардлага	1	16.3	1	16.3	100
3	Зөвлөмж	4	8.3	3	8.3	75.0
Нийт дүн		7	26.5	7	26.5	91.6

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 1,400.2 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 168.6 сая төгрөгийн 8 зөрчил илэрснээс, 1.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 35.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 131.3 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмжийг тус тус өглөө.

Аудитаар илэрсэн 168.6 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитад хамрагдсан 1 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 168.6 сая төгрөгийн 5 санхүүгийн зөрчил илэрснээс, 1.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 35.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 131.3 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг тус тус өгсөн.

5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

5.2.1 Албан шаардлага

1. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 168.6 сая төгрөгийн 5 санхүүгийн зөрчил илэрснээс 1.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 35.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 131.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилтэй харьцуулахад материаллаг дүнгээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 14.2.10 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Зөвлөмж

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд тайлант оны эцэст 50.6 сая төгрөгийн цалин, НДШ, ХХОАТ-тай холбоотой өглөг үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5 “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” 14 дүгээр зүйлийн 14.2 “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн

удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.10 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Монгол Улсын дээд Шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Хангарди ордны барилга нь 2008 онд ашиглалтад орж 22,273.7 сая төгрөгийн өртгөөр нягтлан бодох бүртгэлд тусгагдсан бөгөөд тухайн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон зах зээлийн үнийг үнэлж шинэчлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.3 “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 14 дүгээр зүйлийн 14.2.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.10.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 17 Үндсэн хөрөнгө 17.49 “Дахин үнэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс материаллагаар өөр болсон тохиолдолд дараагийн дахин үнэлгээг хийх шаардлагатай, харин үнэ цэнд ялимгүй бага өөрчлөлт ордог үндсэн хөрөнгийн зүйлсийн хувьд гурав буюу таван жил тутамд дахин үнэлэх шаардлагатай” гэж тус тус заасантай нийцэхгүй байна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тус барилгын бодит үнэ цэнэ болон зах зээлийн үнийг холбогдох хууль, журам, стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэн тогтоох асуудлыг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллах.

5.3 Түүвэрт хамрагдсан байгууллагад илэрсэн санхүүгийн зөрчил

5.3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт-1: Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн төсвийн захирагч нь тайлант онд Б/14 тоот тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан нэг албан хаагчид 1.5 сая төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-т “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”; 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно”, 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгосон зөрчлийг арилгаж, нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.3.2 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 9 нэр төрлийн нийт 25,601.5 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоох, акталж данс бүртгэлээс хасах болон бодит үнэ цэнээр дахин үнэлж бүртгэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг холбогдох журам, стандартын дагуу шинэчлэн тогтоож, ашиглалтгүй болон цаашид ашиглагдах боломжгүй хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасах, шаардлагатай тохиолдолд бодит үнэ цэнээр дахин үнэлж бүртгэх асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар	1	1,400.2	-	-	1	1,400.2	1	1,400.2	-	-	-	-
Дүн	1	1,400.2	-	-	1	1,400.2	1	1,400.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	3	-	-	-	1	-	2	-
Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар	3	167.1	-	-	1	35.8	2	131.3
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи	2	1.5	1	1.5	-	-	1	-
Дүн	8	168.6	1	1.5	2	35.8	5	131.3

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар	1	660.6	1	660.6	-	-
Бусад хууль тогтоомжийн зөрчил						
Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	1	-	-	-	1	-
Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар	1	-	1	-	-	-
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи	1	28.4	1	28.4	-	-
Дүн	4	689.0	3	689.0	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1457/АОМ11371

Улаанбаатар хот

САГ-2026/20/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналт сул байгаагаас тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 168,624,290.31 /нэг зуун жаран найман сая зургаан зуун хорин дөрвөн мянга хоёр зуун ерэн төгрөг гучин нэгэн мөнгө/ төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 5.1.5-д "хариуцлагатай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26 230

Z:\Alban Shaardlaga\2026\0424_SAG-49.Docx

1526182369

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хэрэгжүүлэх дотоод хяналт хангалтгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч /Д.Ганзориг/, Ерөнхий нягтлан бодогч /Д.Сүглэгмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН